БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ
ДАРГА М.ӨЛЗИЙ

9020050812
ТИ23198 ♀ 5292816

# МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2026 ОНЫ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026.08.25

| № | Эрсдэлийн ангилал | Эрсдэлийн тодорхойлолт ба бодит үр дагавар | Магадлал (1-5) | Үр дагавар (1-5) | Эрсдэлийн оноо | Эрсдэлийн түвшин | Урьдчилан сэргийлэх, бууруулах нарийвчилсан арга хэмжээ | Шаардагдах нөөц / Төсөв | Хэрэгжих хугацаа | Хариуцах нэгж / Албан тушаал | Хяналтын шалгуур үзүүлэлт (KPI) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хуурай боомтын зохицуулалт | Далайн захиргаа нь хуурай боомтын барилга, бүтээн байгуулалтад шууд оролцохгүй, зөвхөн ерөнхий зохицуулалт (координаци) хийх үүрэгтэй тул салбар хоорондын (ЗТЯ, Гааль, Хилийн боомтын захиргаа, орон нутаг) уялдаа холбоо алдагдах, нэгдсэн төлөвлөлтөд орохгүй байх эрсдэл. | 3 | 4 | 12 | Дунд | 1. Хуурай боомтын нэгдсэн зохицуулалтыг хангах салбар дундын Ажлын хэсэг / Зөвлөлийг ЗТЯ-ны дэмжлэгтэйгээр байгуулж, тогтмолжуулах.<br>2. Хуурай боомтын менежмент, тээвэр логистикийн зохицуулалтын эрх зүйн баримт бичиг, ТЭЗҮ боловсруулж, талуудаар зөвшөөрүүлэх. | Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг бараа үйлчилгээний төлбөр | 2026 оны тасралтгүй | Далайн тээвэр, хуурай боомтын хэлтэс, Захиргаа, удирдлагын хэлтэс (Гадаад харилцаа хамтын ажиллагаа) | Уулзалтын тогтмолжилт (Сар бүр), Мэдээлэл солилцооны хоцролтгүй байдал |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Хүний нөөцийн эрсдэл | Байгууллагын нарийн мэргэшсэн хөлөг онгоцны бүртгэгч, Улсын байцаагч болон туршлагатай мэргэжилтнүүд ажлаас гэнэт гарах, чадвартай боловсон хүчнээр баг бүрдэж чадахгүй байх, мэргэжлийн залгамж халаа тасарч үйл ажиллагаа доголдох. | 4 | 4 | 16 | Өндөр | -Олон жил тогтвортой ажиллуулах хүний нөөцийн урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.<br>-Мэргэшсэн ажилтнуудыг олон улсын (IMO, APHoMSA) сургалт, гадаад портуудын практик дадлагад үе шаттай хамруулж, карьер өсөлтийн тодорхой зураглалтай болгох.<br>-Гүйцэтгэлийн үнэлгээнд (KPI) суурилсан урамшууллын систем болон нийгмийн баталгааг дэмжих (орон сууцны дэмжлэг, эрүүл мэндийн даатгал г.м) хөтөлбөр нэвтрүүлэх.<br>-Ажлаас гарах эрсдэлийг тооцож, дагалдан сургах (Mentorship) болон залгамж халааны төлөвлөлтийг тогтолцоо болгох. | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2026 оны III улирлаас эхлэн тасралтгүй | Захиргаа, удирдлагын хэлтэс (Хүний нөөц), Удирдах бүрэлдэхүүн | Түлхүүр ажилтнуудын тогтвор суурьшил (>92%), Баг бүрдүүлэлтийн хувь (100%) |
| 3 | Зуны улирлын усан замын хяналт | Зуны улиралд (5-10 сар) Хөвсгөл, Увс, Өгий зэрэг томоохон нууруудад иргэдийн амралт, аялал жуулчлалтай холбоотой усан замын тээврийн хөдөлгөөн эрс нэмэгдэх үед | 4 | 5 | 20 | Өндөр | -Зуны улирлын эрчимжүүлсэн хяналт шалгалтын тусгай төлөвлөгөөг жил бүрийн 5 сараас өмнө баталж, орон нутагт улсын байцаагчдыг хуваарилах.<br>-Орон нутгийн Засаг захиргаа, Мэргэжлийн хяналтын алба, Онцгой байдлын газартай хамтарсан гэнэтийн болон | Дотоод албан томилолт | Жил бүрийн 6-9 сард (Эрчимжүүлсэн үе) | Усан замын тээврийн бүртгэл, хяналтын алба, Орон нутаг дахь төлөөлөгчид | Усан замын тээврийн осол, зөрчлийн тоо = 0, Техникийн үзлэгт хамрагдалтын хувь = 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хяналт суларснаас осол аваар гарах, нуурын экосистемийг бохирдуулах. | | | | | төлөвлөгөөт эргүүл, шалгалтуудыг тогтмолжуулах.<br>-Усан замын тээвэр эрхлэгч, завьтай иргэдэд ХАБЭА болон аюулгүй ажиллагааны заавал мөрдөх сургалт зохион байгуулах, аврах хантаазны хэрэглээнд хатуу хяналт тавих.<br>-Алсын зайн мониторингийг сайжруулах зорилгоор нууруудын экосистемийн ухаалаг хяналтын цэг байгуулах төсөл боловсруулах (KOICA 2028) бэлтгэлийг хангах. | | | | |
| 4 | Хөвөлтийн улирал дуусах | Эрчимжүүлсэн хяналт дууссан үед хууль, стандарт зөрчигдөх, өвлийн зогсоолд байршуулаагүйгээс үүдэлтэй завь гэмтэх, цоорох, мөс хайлах үед живэх, гол нуурыг бохирдуулах | 3 | 4 | 12 | Дунд | -Хөвөлтийн улирлыг зогсоох талаар орон нутгийн Засаг даргад хүсэлт хүргүүлэх.<br>-Усан замын тээврийн хэрэгслүүдийг уснаас гаргах талаар олон нийтэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчноор дамжуулан мэдээлэх, сурталчлах | Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг бараа үйлчилгээний төлбөр | Жил бүрийн 9-10 сард | Усан замын тээврийн бүртгэл, хяналтын алба | Албан хүсэлтийн хүргэлт болон гарсан шийдвэр 100%, Мэдээлэл түгээсэн давтамж болон тээврийн хэрэгсэл уснаас гаргасан хувь >3/95-100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Олон улсын хөлөг онгоцны бүртгэл | Монгол улсын далбааг ашиглаж буй хөлөг онгоцнууд олон улсын хориг арга хэмжээнээс зөрчих болон 'Далд флот' (Shadow Fleet)-д холбогдон улс орны нэр хүнд олон улсын тавцанд унах. | 4 | 5 | 20 | Өндөр | -S&P Global MIRS системийг ашиглан хөлөг онгоцны эцсийн ашиг хүртэгч болон өмнөх түүхийг нарийвчлан шалгах<br>-Далайн салбарын хоригт орсон хөлөг онгоц, хувь хүмүүсийн мэдээллийн санг (OFAC г.м) өдөр тутам тулгах журам мөрдөх.<br>-Эрсдэлтэй гэж үнэлэгдсэн хөлөг онгоцыг бүртгэхээс татгалзах. | Мэдээлэл технологийн үйлчилгээ | Тасралтгүй | Хөлөг онгоцны бүртгэлийн хэлтэс | Хориг зөрчсөн хөлөг онгоцны тоо = 0, Нарийвчилсан шүүлт хийсэн хувь = 100% |
| 6 | Олон улсын хөлөг онгоцны бүртгэл | Хөлөг онгоцны техникийн аюулгүй байдал алдагдаж, олон улсын портуудад (Tokyo MOU, Paris MOU) олноор саатуулагдах (Detention), улмаар далбааны зэрэглэл 'Хар' жагсаалтаас гарч 'Саарал' жагсаалтад орж чадахгүй эрсдэл. | 3 | 5 | 15 | Өндөр | -Хөлөг онгоцны Улсын Байцаагчдын (Flag State Inspector - FSI) биечлэн хийх хяналт шалгалтыг олон улсын стандартад нийцүүлэн тогтмолжуулах.<br>-Монгол Улсыг төлөөлөн үзлэг хийдэг Гэрээт байгууллагуудад (Recognized Organizations - RO) тавих жил бүрийн аудитын хяналтыг чангаруулах. | 1. Гадаад албан томилолт<br>2. Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох | Улирал тутам / Тогтмол | Хөлөг онгоцны бүртгэлийн хэлтэс, Захиргаа, удирдлагын хэлтэс (Гадаад харилцаа хамтын ажиллагаа) | Tokyo & Paris MOU саатуулагдсан хөлөг онгоцны хувь хэмжээ олон улсын дунджаас хэтрэхгүй байх |

**ХЯНАСАН:** ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА Т.МӨНХБАЯР

**БОЛОВСРУУЛСАН:** ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Т.ОТГОНБААТАР